

ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬ-2020

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРАЛД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
ТҮДЭНДОРЖИЙН БОЛДБААТАРЫН  
ДЭВШҮҮЛЖ БУЙ  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020.07.23.

ХӨВСГӨЛ АЙМАГ



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ  
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ТҮДЭНДОРЖИЙН БОЛДБААТАРЫН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит сонгуулийн бие даан нэр дэвшигч Түдэндорж овогтой Болдбаатар би дараах хөтөлбөртэйгөөр сонгуульд оролцож байна. Үүнд:

**Нэгдүгээр бүлэг:**

**Иргэн бүрд чиглэсэн нийгмийн бодлого**

**Хоёрдугаар бүлэг:**

**Иргэн бүрд чиглэсэн эдийн засгийн бодлого**

**Гуравдугаар бүлэг:**

**Иргэн бүрд чиглэсэн байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого**

**Дөрөвдүгээр бүлэг:**

**Иргэн бүрд чиглэсэн эрх чөлөө, шударга ёсыг төлөвшүүлэх**

**Нэг. Иргэн бүрд чиглэсэн нийгмийн бодлого**

1.1 Боловсрол, соёл, урлаг, шинжлэх ухааныг дэмжих бодлого баримтална.

1.2. Цэцэрлэгийн болон сургуулийн насны хүүхэд бүрд төрөөс боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй үзүүлэх, сурч боловсрох орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн бодлого, санаачилгыг дэмжинэ.

1.3. Иргэн бүрд эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй болгохын тулд олон улсын жишигт нийцсэн үзлэг, шинжилгээ, оношилгоонд бүрэн хамрагдуулах зорилгоор анхан шатны өрхийн эрүүл мэндийн төв болон хоёр, гуравдугаар шатлалын эмнэлгүүдээс үзүүлэх үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, анхаарах, энэ чиглэлийн бодлого, санаачилгыг дэмжих;

1.4. Монгол улсын хөгжлийн гарц нь шинжлэх ухаан тул шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын хүний нөөцийг бүрдүүлэх, гаргасан шинэ санал санаачилгыг ажил хэрэг болгоход анхаарч, мэдлэгт суурилсан үйлдвэрлэл хөгжүүлэх бүх санаачилгыг дэмжих;

1.5. Нийтийн биеийн тамир, спортын хөгжлийг бүх талаар дэмжиж хороо бүрд спортын ордонтой болгох асуудлыг судалж, шийдвэрлэнэ.

1.6. Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгож, даатгалаас үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд анхаарна.



1.7. Багш, эмч нарын нийгэмд эзлэх байр суурийг анхаарч, тэдгээрийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарна.

1.8. Төрийн албан хаагчдын ажил үүргээ хэвийн, үр дүнтэй, шударгаар, шуурхай явуулах орчин нөхцөл, цалин хангамж, орон сууцны асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн бодлого, санаачилгыг дэмжих;

1.9. Иргэдэд чиглэсэн нийгмийн хамгааллын бодлогыг дэмжинэ

1.10. Гэр бүл, ахмад настан, эмэгтэйчүүд, хүүхэд залуусын хөгжлийг дэмжинэ

1.11. Ахмад настны цагийн хөдөлмөр эрхлэх боломжийг сайн дурын үндсэн дээр сонголтоор бий болгох, залууст ажлын дадлага, туршлага, мэргэжлийн ур чадвараа өвлүүлэх чиглэлийн бодлого, санаачилгыг дэмжих;

1.12. Иргэдийн аюулгүй, амгалан тайван амьдрах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх идэвхтэй дэмжих- бодлого баримтлах;

### **Хоёр. Иргэн бүрд -чиглэсэн эдийн засгийн бодлого**

2.1. Залуу гэр бүл, дундаж болон дунджаас доош орлоготой гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, ганц бие өрх толгойлсон эцэг, эх, зорилтот бүлгийн өрх, иргэдийг дэмжиж ажиллана.

2.2. Монгол Улсын байгалийн баялгийг тэгш, шударгаар хүртээмжтэй ашиглахыг хуулиар хамгаалах бодлого. үйл ажил; агаа, санал, санаачилгыг дэмжих;

2.3. Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн чадавхтай ажиллах хүчний нөөцийг баялаг бүтээх үйлсэд татан оролцуулах, хөдөлмөрийг бодитоор үнэлдэг, дэмждэг эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

2.4. Аж ахуйн нэгж, байгууллагууд, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг төрийн элдэв дарамт, татаасаа ангид байлгаж, татварын болон бусад хөнгөлөлт, чөлөөлөлтүүдэд хамруулах ажлыг дэмжиж ажиллана.

### **Гурав. Иргэн бүрд чиглэсэн байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого**

3.1. Байгаль орчинд сөргөөр нөлөөлж буй уур амьсгалын өөрчлөлт, агаарын болон хөрсний бохирдол, усны нөөцийн хомсдолыг бууруулахад онцгой анхаарч экологийн тэнцвэрт байдлыг хадгалан хамгаалахад бүх талаар дэмжиж ажиллах;

3.2. Агаарын бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд байгальд ээлтэй эко-техник, технологийн хэрэглээг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах;

3.3. Аймгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, усан сан, усан оргилуур байгуулж, хотын иргэдийнхээ чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, амьдрах

таатай орчныг бүрдүүлэх бодлого, санаачилгыг хэрэгжүүлэх;

3.4. Иргэдээс байгаль орчныг хамгаалах, ногоон байгууламж бий болгох, эко системийг дэмжих талаар гаргасан санал санаачилга, төслийг дэмжих замаар агаар, орчны бохирдлыг бууруулахад бодит хувь нэмэр оруулна.

**Дөрөв. Иргэн бүрд чиглэсэн эрх чөлөө, шударга ёсыг төлөвшүүлэх**


4.1. Шударга ёсыг тууштай ,ахиулж. хүний эрхийг дээдэлсэн тогтолцоог бий болгоход өөрийн хувь нэмрийг оруулах

4.2. Иргэн бүр хууль, шүүхийн өмнө тэгш байх, хууль ёсны эрхээ хамгаалуулах боломжийг олгох, эрх зүйн шинэчлэл дэмжих, шүүхийн хараат бус, бие даасан байдлыг хангахад өөрийн хувь нэмрийг оруулах

4.3. Ил тод, шударга сонгон шалгаруулалтаар төрийн албыг мэргэшсэн, чадварлаг хүний нөөцөөр бүрдүүлж ажиллахыг бүх талаар дэмжинэ. Улс төрийн сонгуулийн үр дүнгээр төрийн мэргэшсэн албан хаагчдыг хомрогдон халах явдлыг таслан зогсоох;

4.4. Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай, шат дамжлагагүй хүргэх ажлыг бүхий л хэлбэрээр дэмжин төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, төрийн өмчийн эзэмшилд хяналт тавьж сонгогчдод тайлагнах;

БОЛОВСРУУЛСАН:



Т.БОЛДБААТАР

Холбоо барих: 99112701

88111965

